МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2015.07.20 № 01/2292

танай ____________-ны №____________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас гаргах мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 8 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА НАРИУНБОЛД

0002079

d:\хxaая-ны албан бичгүүд\а5-15.docx

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2015 оны эхний хагас жилийн байдлаар/

| № | Хэлэлцүүлэх асуудлын агуулга | Гарсан шийдвэр, огноо |
|---|---|---|
| 1. | "Цаа бугын аж ахуйг хөгжүүлэх цаатан иргэдийн амьдралын түвшинг сайжруулах" хөтөлбөрийн 2014 оны хэрэгжилтийн тайлан /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | 1 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. |
| 2. | Хүнс, хөдөө аж ахуйн сайд ХБНГУ-д зохион байгуулагдах "Ногоон долоо хоног"- Олон улсын үзэсгэлэн, Хөдөө аж ахуйн Сайд нарын дээд хэмжээний уулзалтад оролцох тухай /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. /Хуралдааны 2 дугаар тэмдэглэл/ |
| 3. | "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний малчдын бүлэг", "Улсын тэргүүний фермер", "Улсын тэргүүний малчдын хоршоо" шалгаруулах тухай /Засгийн газрын тогтоол/ | 2 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. /Засгийн газрын 39 дүгээр тогтоол/ |
| 4. | "Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 2 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. |
| 5. | Улаанбуудайн урамшуулал олгох тухай /Засгийн газрын тогтоол/ | 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. /"Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 31 дүгээр тогтоол/ |
| 6. | Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл | 6 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. УИХ-д өргөн барихыг дэмжсэн. /Хуралдааны 32 дугаар тэмдэглэл/ |
| 7. | Малын эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн төсөл | 6 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. УИХ-д өргөн барихыг дэмжсэн. /Хуралдааны 32 дугаар тэмдэглэл/ |
| 8. | Органик хүнсний тухай хуулийн төсөл | 6 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. УИХ-д өргөн барьсан. /Хуралдааны 32 дугаар тэмдэглэл/ |
| 9. | Мал аж ахуйн хаваржилтын нөхцөл байдлын талаар танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | ОБЕГ-тай хамтран асуудал боловсруулж, 4 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. /155 дугаар тогтоол/ |
| 10. | Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай /Засгийн газрын тогтоол/ | 6 дугаар сард багтаан хэлэлцүүлэхээр тогтоолын төсөлд яамдаас санал авч |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байна. | | | |
| 11. | Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын тогтоол/ | 6 сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлнэ. | | | |
| 12. | Хаврын тариалалтын бэлтгэл хангасан дүнгийн тухай танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанд танилцуулав. | | | |
| 13. | Ургамлын генетик нөөцийн тухай олон улсын гэрээнд нэгдэн орох тухай /Засгийн газрын тогтоол/ | | | + | |
| 14. | Тариалалтын эцсийн дүнгийн танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | | | + | |
| 15. | Ургацын урьдчилсан балансын танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | | | + | |
| 16. | Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнгийн тухай танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | | | | + |
| 17. | Ургац хураалтын дүнгийн танилцуулга /Засгийн газрын хуралдааны тэмдэглэл/ | | | | + |
| 18. | Засгийн газрын хуралдаанаар 2015 оны эхний хагас жилд хэлэлцүүлсэн болон танилцуулсан төлөвлөгөөнд ороогүй асуудлын тоо | **16** | | | |

## САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөл 4 удаа хуралдаж 19 асуудал хэлэлцсэн байна. Үүнд:

| № | Хуралдаанаар хэлэлцсэн асуудал | Огноо | Гарсан шийдвэр |
|---|---|---|---|
| 1. | Хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх | 2015.02.11 | Тэмдэглэл |
| 2. | Хүнсний үйлдвэрлэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх | 2015.02.11 | Тэмдэглэл |
| 3. | Завхан-Буурал ямааны үүлдрийн тодорхойлолт | 2015.02.11 | Тэмдэглэл |
| 4. | “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл | 2015.04.15 | Зөвлөмж |
| 5. | “Малын бруцеллёзтай тэмцэх стратеги” | 2015.04.15 | Зөвлөмж |
| 6. | “Ургамал, түүний гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, загвар, түүнийг хэрэглэх журам” | 2015.04.15 | Зөвлөмж |
| 7. | Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон гадаад хорио цээртэй болон хязгаарлагдмал тархалттай ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, мэрэгчдийн жагсаалт | 2015.04.15 | Зөвлөмж |
| 8. | Өвөрхангай аймгийн Баянгол суманд үржүүлж буй Шинэ хэвшлийн /удмын/ хонины тодорхойлолт | 2015.04.15 | Зөвлөмж |
| 9. | Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Өндөр суманд үржүүлж байгаа Залаа жинстийн цагаан омгийн ямаа үүлдэр болгохоор явуулсан үржил селекцийн ажлын үр дүнд хянан магадлагаа хийсэн тухай танилцуулга | 2015.04.15 | Зөвлөмж |
| 10. | Хөвсгөл аймагт үржүүлж буй “Дархад” омгийн хонийг үүлдрээр баталгаажуулах үржлийн ажлын хянан магадлагаа хийсэн тухай танилцуулга | 2015.04.15 | Зөвлөмж |
| 11. | Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга | 2015.05.27 | Зөвлөмж |
| 12. | Хурдан морины стандарт | 2015.05.27 | Зөвлөмж |
| 13. | “Газар тариалангийн тогтвортой хөгжил” үндэсний хөтөлбөр | 2015.05.27 | Зөвлөмж |
| 14. | “Хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдал” дэд хөтөлбөр | 2015.05.27 | Зөвлөмж |

| | | | |
|---|---|---|---|
| 15. | "Тусламж хандиваар малын эм, эмнэлэгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам" | 2015.05.27 | Зөвлөмж |
| 16. | Төхөм тунгалагийн хүрэн тэмээний үржлийн хэсгийн үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийсэн ажлын дүн | 2015.07.03 | Зөвлөмж |
| 17. | Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумдад үржүүлж буй махны чиглэлийн "Буриад" хонийг омгоор баталгаажуулах үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийсэн ажлын тайлан | 2015.07.03 | Зөвлөмж |
| 18. | "Мал эмнэлгийн ариун цэвэр, хорио цээрийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам" | 2015.07.03 | Зөвлөмж |
| 19. | "Худгийн зориулалтаар өрөмдсөн цооног бага устай юм уу, усгүй байх тохиолдлыг хянан магадлах, санхүүжүүлэх журам" | 2015.07.03 | Зөвлөмж |

...............оОо..................

## МАХНЫ ХАНГАМЖ, НӨӨЦИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

Улаанбаатар хотын хүн амын 2015 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, хадгалах, ангилан савлах, худалдаалах үйл ажиллагааг гүйцэтгэх нөөцийн махны менежерийн 1 дүгээр багцад “Эи Эн Ди Эм” ХХК, 2 дугаар багцад “Мах импекс” ХК, 3 дугаар багцад “Баатарууд тэнгэр” ХХК, 4 дүгээр багцад “Мах маркет” ХХК-ийг тус тус шалгаруулж, оролцогч тус бүр 3000 (гурван мянга) тонн махны нөөц, мөн Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2015 оны хэрэгцээнд зориулан “Нөөцийн махны менежер”-ийн төсөл сонгон шалгаруулалтын шаардлагыг хангасан Дархан хотын багцад 1000 (нэг мянга) тонн махны нөөц бүрдүүлэх “Нөөцийн махны менежер”-ээр “Дархан мийт фүүдс” ХХК-ийг, Эрдэнэт хотын багцад 1000 (нэг мянга) махны нөөц бүрдүүлэх “Нөөцийн махны менежер”-ээр “Эрдмийт” ХХК-ийг тус тус шалгаруулж, МХЕГ, ОБЕГ-уудтай хамтран дөрвөлсөн гэрээг байгуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотын хүн амын 2015 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан 14000 тонн нөөцийн мах бэлтгэхээс 14,544.6 тонныг бэлтгэж, нөөцийн махыг 104% бүрдүүлсэн.

2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар Улаанбаатар хотод “Баатарууд тэнгэр” ХХК 3,212.7 тн, “Мах импекс” ХК 3,112.1 тн, “Мах маркет” ХХК 3.006.5 тн, “Эй Эн Ди Эм” ХХК 3,035 тн, Дархан хотод “Дархан мийт фүүд” ХХК 1081.4 тн, Эрдэнэт хотод “Эрдмийт” ХХК 1096.9 тн, нийт 14,544.6 тонныг тус тус бэлтгээд байна. УИХ-ын 2013 оны 11 сарын 14-ний 62 дугаар тогтоолын 4.1-д заасны дагуу зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх зорилгоор хөтөлбөрийн санхүүжилтийн 40%-ийг банкны өөрийн эх үүсвэрээр, 60%-ийг Монголбанкны эх үүсвэрээр санхүүжүүлж байна. Махны үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд Монгол банкнаас нийт 46,2 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байна. Үүнд:

| Банкууд | Нөөцийн менежер | Олгосон /сая ₮/ | Үлдэгдэл /сая ₮/ |
|---|---|---|---|
| Голомт | Эй Эн Ди Эм ХХК | 9,900.0 | - |
| | Мах импекс ХК | 9,900.0 | - |
| ХХБ | Баатарууд тэнгэр ХХК | 9,900.0 | - |
| | Дархан мийт фүүд ХХК | 3,300.0 | - |
| Хас | Мах маркет ХХК | 9,900.0 | - |
| Хаан | Эрдмийт ХХК | 3,300.0 | - |
| | | **46,200.0** | - |

2015 оны нөөцийн махны борлуулалт нь 3 дугаар сараас эхэлсэн. Учир нь 2014 оны урамшууллын үлдэгдэл 4,5 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдсэн тохиолдолд “Нөөцийн махны менежментийн гэрээ”-ний дагуу нөөцийн махыг борлуулж эхлэхээ мах бэлтгэсэн компаниуд мэдэгдсэн юм.

ХХААЯ-наас Засгийн газар, Сангийн яаманд санал гаргасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 105 дугаар тогтоолоор өнгөрсөн оны нөөцийн махны урамшууллын зардлын үлдэгдэл 4.5 тэрбум төгрөгийг векселиэр санхүүжүүлэх тухай шийдвэрлэгдэж, нөөцийн мах

бэлтгэсэн компаниуд борлуулалтаа эхэлсэн. Гэвч өнөөдрийг хүртэл энэхүү 4,5 тэрбум төгрөг олгогдоогүй байна.

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2015 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулан 14.5 мянган тонн нөөцийн мах бэлтгэснээс 2015 оны 6 дугаар сарын сүүлийн байдлаар 11,2 мянган тонныг борлуулж, нөөцийн махны борлуулалт 80%-тай байна.

Энэ онд махны үнэ өсөх улирлын хамгийн өндөр нөлөөлөлтэй 1, 2 дугаар сард махны үнэ харьцангуй тогтвортой байж сарын инфляцид харгалзан 0.10, 0.33 нэгж хувийн нөлөө үзүүлээд байсан бол 3, 4 сард харгалзан 0.63, 0.93 нэгж хувь болон нэмэгдсэн. Энэхүү нөлөөлөл нь 2010-2014 оны 1, 2, 3, 4 дүгээр сарын дунджаар харгалзан 1.23, 1.03, 0.73, 0.60 нэгж хувь байсан байна. Өөрөөр хэлбэл 2015 оны 3, 4 дүгээр сард инфляцид махны үнийн нөлөөлөл өмнөх жилүүдийн дундажтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

2015 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар нөөцийн махны урамшууллын зардал 14,0 тэрбум төгрөгийг хассан тул “Нөөцийн махны менежментийн гэрээ”-ний 8.2-т заасны дагуу гэрээнд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг нөөцийн махны менежер компаниудад хүргүүлсэн. Гэвч компаниуд гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж нөөцийн махыг бэлтгэж дууссан тул уг мэдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй, Захиалагч буюу тухайн үеийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамыг гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг шаардаж байгаа юм.

2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан уг гэрээ нь хүчин төгөлдөр байгаа тул одоогийн Хүнс, хөдөө аж ахуйн яам гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж нөөцийн махыг бэлтгэсэн компаниудад урамшууллын зардлыг олгох хууль ёсны шаардлагатай тулгараад байна. Энэхүү урамшууллын зардал нь “Нөөцийн махны менежментийн гэрээ”-ний 5.1-т заасны дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын багцад тусгагдсан санхүүжилтийн эх үүсвэрээс гаргах байсан боловч Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдаагүй болно.

## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ 2015 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

/сая төгрөг/

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2015 онд санхүүжих | Санхүүжилтын гүйцэтгэл | Гүйцэтгэгч компанийн нэр | Дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **XXI** | **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД** | | | **21,877.1** | **3,507.9** | **591.9** | | |
| **XXI.1** | **I.Хөрөнгө оруулалт** | | | **20,847.1** | **2,971.9** | **57.8** | | |
| | Шилжих | | | 20,847.1 | 2,971.9 | 57.8 | | |
| XIII.1.1 | Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор сум/ | 2012 | 2016 | 12,271.0 | 1,000.0 | | "Набсан" ХХК | Тендерийг 2013 онд зарлан гүйцэтгэгчээр шалгарсан "Набсан" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Барилга угсралтын ажил 84 хувийн гүйцэтгэлтэй байна |
| XIII.1.2 | Буянт голын усалтын систем /Ховд/ | 2013 | 2015 | 2,224.8 | 371.3 | | "Монгол менежиент төв" ХХК | 2013 онд хийгдсэн ажлыг 2014 онд СЯ-наас вексель бичигдэн санхүүжүүлсэн байна. |
| XIII.1.3 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд/ | 2012 | 2016 | 5,000.0 | 1,250.0 | | | Тус арга хэмжээний эрхлэх асуудал аж үйлдвэрийн яаманд шилжсэн тендер шалгаруулалтыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж байна. |
| XIII.1.4 | Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 2013 | 2016 | 1,351.3 | 350.6 | 57.8 | "Ди Си Эйч" ХХК | Тендерийг 2013 онд зарлан гүйцэтгэгчээр шалгарсан "Ди Си Эйч" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Барилга угсралтын ажил 37 хувийн гүйцэтгэлтэй байна |
| **XXI.2** | **II.Их засвар** | | | **30.0** | **30.0** | **28.3** | | |
| | Шилжих | | | 30.0 | 30.0 | 28.3 | | |
| XIII.2.1 | Мал эмнэлгийн лабораторийн уурын зуухын их засвар /Сүхбаатар/ | 2015 | 2015 | 30.0 | 30.0 | 28.3 | "Гэгээн харваах" ХХК | Тендерийг 2014 онд зарлан гүйцэтгэгчээр шалгарсан "Гэгээн харваах" ХХК-тай гэрээ байгуулан ажилласан байна. Барилгын засварын ажлыг 2014 онд 100 хувь гүйцэтгэсэн санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |
| **XXI.5** | **V.Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг** | | | **1,000.0** | **506.0** | **505.8** | | |
| | Шилжих | | | 1,000.0 | 506.0 | 505.8 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| XIII.5.1 | Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах | 2012 | 2015 | 1,000.0 | 506.0 | 505.8 | "Мөнх ногоон тал" ХХК | Тендерийг 2013 онд зарлан гүйцэтгэгчээр шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК-тай гэрээ байгуулан ажилласан байна. Ажлыг 2013 онд 100 хувь гүйцэтгэсэн тул санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |

## ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭР, ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГӨӨР 2015 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2015 онд санхүүжих | Санхүүжилтын гүйцэтгэл | Гүйцэтгэгч компанийн нэр | Дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **III** | **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД** | | | **16,000.0** | **8,000.0** | **7,995.0** | | |
| **III.1** | **I.Хөрөнгө оруулалт** | | | **16,000.0** | **8,000.0** | **7,995.0** | | |
| III.1.1 | Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах /Дархан-Уул, Дархан сум/ | 2014 | 2015 | 16,000.0 | 8,000.0 | 7,995.0 | "Дархан гурил тэжээл" ХК | Тендерийг 2014 онд зарлан гүйцэтгэгчээр шалгарсан "Дархан гурил тэжээл" ХК-тай гэрээ байгуулан ажилласан байна.архан-Уул аймагт үр тариа хадгалах 36.0 мянган тонн багтаамжтай төмөр бетон элеваторын Тармалан эрхлэлтийг дэмжих санд хүлээлгэн өгсөн. |